



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 609

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 11 нэрийн, нийт 337,895,309.68 (гурван зуун гучин долоон сая найман зуун ерэн таван мянга гурван зуун есөн төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 94,250,000.00 (ерэн дөрвөн сая хоёр зуун тавин мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын-ны өдрийн
609 дугаар тогтоолын хавсралт

Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй, ашиглах хугацааг
сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдса н элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Соната-7, 05-93 УБҮ	3/1/2016	54,700,000.00	1	54,700,000.00	5,000,000.00	1	5,000,000.00	2
2	Процессор	4/6/2018	2,640,000.00	6	15,840,000.00	133,333.33	6	800,000.00	2
3	Канон /Canon IR2002N/-ДГ	12/25/2012	1,895,740.00	1	1,895,740.00	250,000.00	1	250,000.00	2
4	Ном электрон хэлбэрт хувиргагч	4/15/2014	182,028,500.00	1	182,028,500.00	80,000,000.00	1	80,000,000.00	4
5	Компьютер /inspiron On 23 Touch Base ДГ/	12/25/2012	2,546,996.00	1	2,546,996.00	350,000.00	1	350,000.00	2
6	Зөөврийн компьютер /CPU Intel Core i7 -7600U Process-265/	5/3/2018	4,455,358.57	11	49,008,944.27	81,818.18	11	900,000.00	2
7	Interactive digital signage with touch screen WOS-ДГ	12/25/2012	6,444,951.80	1	6,444,951.80	1,200,000.00	1	1,200,000.00	2

8	Router	4/15/2014	2,481,280.10	1	2,481,280.10	800,000.00	1	800,000.00	2
9	Компьютер-Floor stand	4/15/2014	6,444,951.79	1	6,444,951.79	2,500,000.00	1	2,500,000.00	2
10	Компьютер /Дүрс бичлэгийн компьютер, дэлгэц, mous/	4/15/2014	16,003,945.72	1	16,003,945.72	2,300,000.00	1	2,300,000.00	2
11	Усны аппарат 500	1/30/2017	500,000.00	1	500,000.00	150,000.00	1	150,000.00	2
	Нийт дүн			26	337,895,309.68 (гурван зуун гучин долоон сая найман зуун ерэн таван мянга гурван зуун есөн төгрөг жаран найман мөнгө)		26	94,250,000.00 /ерэн дөрвөн сая хоёр зуун тавин мянган/	